

Аймгийн Засаг даргын 2024 оны.....дүгээр сарын.....-ны өдрийн..... дугаар албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 дугаар сарын 02

Арвайхээр сум

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР					
1	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулах, хуулийг дагалдан норм стандарт, дүрэм, журмыг боловсруулахад хамтран ажиллах.		Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагдсан байх.	Хуулийн төслийг УИХ-аар батлуулсан байна. Холбогдох норм стандарт, дүрэм, журмын төслийг боловсруулж батлуулсан байна.	“2018-2020 онд “Хот байгуулалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд 1 санал боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Хэрэгжилт-100.0 хувь
2	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, Хот байгуулалтын кадастрын цахим системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.		Холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан байна.	Аймгийн төв хотуудын барилга байгууламж, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж, зам, тээврийн өгөгдлийн санг үе шаттайгаар бүрдүүлж, Хот байгуулалтын кадастрын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Хот байгуулалтын кадастрын цахим системийн программыг бүрэн ашиглалтад оруулж 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Архитектур төлөвлөлтийн даалгавар-38, Барилгын ажил эхлүүлэх 33, үргэлжлүүлэх 3 зөвшөөрлийг хүсэлтийн дагуу шийдвэрлэж шинэчлэгдсэн “Хот байгуулалтын кадастр”-ын цахим системд боловсруулалт хийж гаргасан байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, “Смарт дата” ХХК-ны нэвтрүүлж байгаа “Хот байгуулалтын кадастр”-ын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдэн хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх хүрээнд тухай бүр холбогдох мэргэжилтнүүдийн хамт танхим сургалтуудад 1 удаа, цахим сургалтад 2 удаа хамрагдсан

					байна. Мөн хот байгуулалтын кадастрын цахим системд гарч байгаа алдааг тухай бүр “Смарт дата” ХХК болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Кадастрын мэргэжилтнүүдэд санал хүргүүлэн засварлуулж хамтран ажиллаж байна. Барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж, зам, тээврийн өгөгдлийн санг үе шаттайгаар бүрдүүлж, Хот байгуулалтын кадастрын цахим системд нэвтрүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт-100.0 хувь
3	Аймгийн ерөнхий архитекторын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнг хагас бүтэн жилээр үнэлэн тус яаманд хүргүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу, Ерөнхий архитекторын үйл ажиллагааны үр дүн	Үйл ажиллагааг үнэлж ирүүлсэн байна.	Аймгийн ерөнхий архитекторын үйл ажиллагааны тайланг жил болгоны 1 дүгээр сарын 15-ны дотор Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж хэвшсэн. 2023 оны үйл ажиллагааны тайланг 2024 оны 1 дүгээр сарын 15-нд хүргүүлж, 2023 оны үйл ажиллагаа 83.0 хувьтай үнэлэгдсэн. Хэрэгжилт-90.0 хувь
4	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл”, арга хэмжээг санаачлах, хэрэгжүүлэхэд санал зөвлөмж авах.		Санал, зөвлөмжийн тоо	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх.	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх хүрээнд Уянга сумын Жаргалант багийн зохион байгуулалтгүй суурьшил үүссэн 25 га талбайд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгавар боловсруулж Барилга, хот байгуулалтын яамаар хянан батлуулсан. Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй дараах барилгуудыг буулгаж суурин дээр нь шинээр барих барилгын ажлын зураг төсөвт буулгах зураг төсвийг боловсруулан хүлээн авч ажилласан. Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хуучин өргөтгөлийн барилгыг буулгаж 320 хүүхдийн сургуулийн барилга, Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын хуучин агуулахын барилгыг буулгаж лаборатори, конторын барилга, Хүүхдийн төлөө төвийн хуучин барилгыг буулгаж Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга, Гучин-Ус сумын хуучин бага сургуулийг буулгаж 250 суудалтай Спорт заалны барилга, Өлзийт

					сумын хуучин эмнэлгийн барилгыг буулгаж 15 ортой эмнэлгийн өргөтгөлийн барилга, Хархорин сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хуучин агуулахыг буулгаж 320 хүүхдийн сургуулийн барилгыг төлөвлөлтийн дагуу суурин дээр нь барилгуудын угсралтын ажил явагдаж байна. Барилгын гүйцэтгэл 30-60 хувийн гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилт-90.0 хувь
5	Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Үндэсний хороо болон БХБЯ, захиргаатай хамтран зохион байгуулна.		Холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан байна.	“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хамтран ажилласан байна.	“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдсан “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн дагуу “Шинэ Хархорум” хотыг байгуулах болсонтой холбогдуулан нөлөөлөлд өртөж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сонсох ажиллагааг зохион байгуулан, урьдчилан тохиролцож, хот байгуулах газрын хил заагийг тодорхойлох ажлыг зохион байгуулсан. Тухайн сонсох ажиллагааг зохион байгуулснаар Улсын тусгай хэрэгцээний газартай давхцалтай газар өмчилсөн иргэн 1585, эзэмшилтэй 538 иргэн, газар эзэмшиж, ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллага 107 нийт давхцалтай 2230 нэгж талбар байгааг тодорхойлсон. Хэрэгжилт-100.0 хувь
6	Монгол Улсын Үндсэн хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулинд нийцүүлэн хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа, тооцоог боловсруулах ажлын хүрээнд холбогдох мэдээлэл, судалгаагаар хангах, БХБЯ-тай хамтран ажиллах.		Холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан байна.	Холбогдох мэдээлэл, судалгаагаар хангаж, хамтран ажилласан байна.	Монгол Улсын Үндсэн хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хот, суурин газарт улс, орон нутгийн зэрэглэл тогтоох судалгаа, тооцоолол хийхээр ажиллаж байна. Хэрэгжилт-30.0 хувь
7	Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолын дагуу “Улс орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө”-өөр баригдсан түрээслэх, түрээслүүлээд өмчлүүлэх зориулалт бүхий орон	300 сая	Түрээсийн орон сууцанд хамрагдсан иргэдийн тоо	Зорилтот бүлгийн иргэд түрээслэх, түрээслүүлээд өмчлөх орон сууцанд хамрагдсан байна.	Түрээслэх, түрээслүүлээд өмчлүүлэх зориулалт бүхий орон сууц баригдаагүй байна. Хэрэгжилт-30.0 хувь

	сууцанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах хүрээнд тухай бүр иргэдийн хүсэлтийг авч, холбогдох журмын дагуу нээлттэй, ил тод шийдвэрлэж ажиллах, улирал бүр тус яаманд тайлан, мэдээ ирүүлэх.				
8	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн дэд бүтцийн ажил хийгдсэн, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой газруудыг орон нутгийн хэрэгцээнд авч, орон сууцны хороолол барих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай хамтран ажиллах, санал боловсруулах, холбогдох тооцоо, судалгааг боловсруулах, урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулах.		Боловсруулсан болон хэрэгжүүлж буй төсөл, ТЭЗҮ, түрээсийн орон сууц барих зорилгоор орон нутгийн хэрэгцээнд авсан газрын тоо.	Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хороолол барих боломж бүхий газрыг өмчлөлд авч, холбогдох тооцоо, судалгаа, ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.	Арвайхээр хотын шинэ суурьшлын бүсэд 20 га талбайд шинээр орон сууцны хорооллын барилгажилтын төсөл хэрэгжүүлэхээр 1600 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтцийн зураг төслийг боловсруулаад байна. Тухайн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, батлуулан хүлээн авч “Хот байгуулалтын кадастр”-ын мэдээллийн цахим санд оруулсан. Мөн аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Аймаг болон сумын төвүүдэд нийтийн орон сууцны зориулалттай газруудыг орон нутгийн хэрэгцээнд авч, иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцаар хангах төслүүдийг хэрэгжүүлэх” саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулаад байна. Хэрэгжилт-90.0 хувь
9	Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууц санг бүрдүүлэх, түрээсийн орон сууцны төсөл хэрэгжүүлэх захиалагчид газар, дэд бүтцийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох. Улирал бүр тус яаманд тайлан, мэдээлэл ирүүлэх.		Түрээсийн орон сууц барих зориулалтаар олгосон газар, дэд бүтцийн тоо.	Орон нутгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан нэмэгдэж, зорилтот бүлгийн иргэд орон сууцаар хангагдах боломж бүрдсэн байна. Газар, дэд бүтцийг олгосон байна.	Түрээсийн орон сууц санг одоогоор бүрдүүлээгүй байна. Хэрэгжилт-30.0 хувь
10	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах бүтцийн нэгжийг байгуулж, орон нутгийн хөгжлийн ерөнхий		Батлуулсан байршлын болон	Амины орон сууц барих бүсүүдийг нарийвчлан	Арвайхээр сумын 5 дугаар багийн “Спортын гудамж”-нд төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсэг 1 га талбайн 0.85 га талбайд

	төлөвлөгөөтэй уялдуулан амины орон сууц барих бүсүүдийг тодорхойлж, эхний ээлжийн байршлыг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулах.		авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	тогтоож, ИТХ-аар батлуулсан байна.	дахин төлөвлөж 132 айлын 5 орон сууцны барилга баригдаж ашиглалтад орсон. Одоогийн байдлаар дахин 122 айлын орон сууцны барилга баригдаж байна. 2023 онд Арвайхээр сумын 5 дугаар багийн төвд төлөвлөлтгүй олгогдсон Өнөр хэсгийн 1 га өрхийн хэрэгцээний 11 нэгж талбайд 9 блок 181 айлын орон сууцны барилгуудыг цогцолбороор барьж ашиглалтад оруулж барилгажуулсан. Үүнээс үлдсэн 11 га талбайд “Барилгажилтын төсөл” ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран тухайн хэсгийн иргэдтэй хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Хэрэгжилт-90.0 хувь
11	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага MNS 6877:2020 стандартын хэрэгжилтийг хангуулж, ажиллах.		MNS 6877:2020 стандартаар тавигдах шалгуур үзүүлэлтийг хангах	Амины орон сууцны зориулалттай газрын ашиглалт, нөхцөл сайжирсан байна.	Гэр хорооллын төлөвлөлт хийхэд баримтлах аргачилсан зааврыг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар жил бүр хэрэгжүүлж ажиллах чиглэл хүргүүлж байна. Мөн сумдын газрын даамлуудыг төлөвлөгөөт сургалтад аргачилсан зааврыг хэрэгжүүлэх талаар сургалт мэдээлэл өгч ажиллаж байна. Энэхүү арга зүйн заавар нь сум суурин газарт гэр хороолол байгуулах, одоо байгаа гэр хорооллыг тохижуулах, цаашид Хот байгуулалтын хууль, норм дүрмийг чанд баримтлах, иргэдийн амьдрах орчныг сайжруулах “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04” Гэр хорооллын төлөвлөлт хийхэд баримтлах аргачилсан зааврыг “Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-нд баримталж ажилласнаар газрын ашиглалт, MNS 6877:2020 стандарт, хот гэр хорооллын дэд бүтцийн архитектур орон зай сайжирч иргэдийн ая тухтай аюулгүй эрүүл орчинд амьдрах нөхцөл бүрдэх юм. Хэрэгжилт-90.0 хувь

12	Газар хөдлөлт болон галд тэсвэртэй, хөрсний бохирдолгүй, ариун цэврийн болон эрчим хүчний хэмнэлттэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан, тухайн орон нутгийн цаг уур, бүс нутгийн онцлогт тохирсон, хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран боловсруулж батлуулан, иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах.		Нэг маягийн загвар зургын дагуу баригдсан орон сууцны тоо	Нэг маягийн загвар зураг боловсруулагдаж, иргэдэд хүрсэн байна	Амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг “Барилгын хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газарт боловсруулж байна. Аймгийн хэмжээнд газар хөдлөлтөд тэсвэртэй хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургаар барилга баригдаагүй. Хэрэгжилт-30.0 хувь
13	Монгол Улсын хэмжээнд 2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарласан болон хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд шилжин суурьших хүсэлтэй иргэн, өрхөд шаардлагатай амьдрах, оршин суух газрыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу саадгүй олгож ажиллах.		Шилжин суурьшиж байгаа иргэдэд олгосон газрын тоо	Шилжин суурьших хүсэлтэй иргэн, өрхөд амьдрах, оршин суух зориулалттай газрыг саадгүй олгосон байна. Тоо хэмжээ:Гомдол үүсээгүй байх.	Улаанбаатар хотоос 2024 онд шилжин ирсэн 25 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олголт хийгдсэн. Тухайн газар олголтын хувьд ямар нэгэн гомдол гараагүй байна. Хэрэгжилт-100.0 хувь
14	Нийтийн эдэлбэр газрыг бүртгэлд авах, зориулалтын дагуу ашиглах, хамгаалах, хяналт тавих чиглэлээр хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээг авч ажиллах		Нийтийн эдэлбэр газрыг бүртгэл, хил зааг солбилцлын баталсан тоо.	Нийтийн эдэлбэр газрыг бүртгэлжүүлж, хил зааг солбилцлыг баталсан байна.	“Аймгийн нийтийн эдэлбэрийн газрын зориулалт,хэмжээ, зааг, ашиглалтын журам”-ын төсөл боловсруулсан. Холбогдох мэргэжлийн байгууллагуудаар тус журмын төсөлтэй холбогдуулан хэлэлцүүлэг хийж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар төлөвлөж байна. Ингэснээр аймгийн хэмжээнд сумын төв, суурин газрын нийтийн эдэлбэр газрыг бүртгэлд авах, хамгаалах, хяналт тавих боломж бүрдэнэ. Хэрэгжилт-70.0 хувь.
15	Ундны усны эх үүсвэр түүний тэжээгдлийн муж, усны сан бүхий газрын хориглолт, хамгаалалтын бүсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тогтоон баталгаажуулах, Газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх		Мэдээлэлийн санд бүтгэгдсэн ундны усны эх үүсвэр, түүний тэжээгдлийн муж, усан сан хүрий газрын хориглолт, хамгаалалтын бүсийн	Хориглолт, хамгаалалтын бүсийг тогтоон баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэсэн байна.	Арвайхээр сумын Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсчлэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар санал оруулан батлуулсан. Газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх ажил хийгдэж байна. Мөн Арвайхээр сумын Өндрийн усан сан болон 2-р өргөлтийн усан сан, Онгийн гол дагуух ундны усны эх үүсвэрийн усан хангамжийг дотоодын цэргийн 833 дугаар

			баталгаажуулсан шийдвэрийн тоо.		ангийн салбартай гэрээ байгуулан байнгын харуул хамгаалалтад авсан. Хэрэгжилт-100.0 хувь
16	Төвлөрсөн инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, авто зам, төмөр замын хяналтын зурвас газрыг хууль тогтоомжид заасны дагуу тогтоон баталгаажуулах, Газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх		Газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлсэн зурвас газрын тоо	Хамгаалалт, хяналтын зурвас газрыг тогтоон баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэсэн байна.	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүсчлэлийг сумдын даамлуудаар дамжуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар санал оруулан батлуулж байна. Энэ онд Гучин-Ус, Хайрхандулаан, Сант сумд инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас тогтоолгоод байна. Хэрэгжилт-70.0 хувь
17	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаа сумдад өндөржилт төлөвлөлтийн ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө, сумын хөгжлийн сан болон бусад техник туслалцаа, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах		Холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт нийцсэн байна.	Өндөржилт төлөвлөлтийн ажил зохион байгуулагдсан байна	Аймгийн хэмжээнд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан Хархорин, Есөнзүйл, Тарагт, Өлзийт, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Бүрд, Баян-Өндөр нийт 8 сум байна. Тус сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2025 онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх чиглэл хүргүүлээд байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаварт өндөржилт төлөвлөлтийн ажлыг тусган ажиллаж байна. Энэ онд Нарийнтээл сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авч хот байгуулалтын кадастрын системд оруулан баталсан. Хэрэгжилт-90.0 хувь
18	Шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг БХБЯ-тай хамтран хэрэгжүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу батлагдсан ажлын даалгаврын хүрээнд боловсруулагдсан байх.	2024 онд 1-2 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан байна.	Шинээр 2 сум шинэчилж байгаа 1 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг Барилга, хот байгуулалтын ямаар хянан батлуулж одоогийн байдлаар Хужирт, Нарийнтээл сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Сайдын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр хянагдаж байна. Хэрэгжилт-90.0 хувь
19	Аймгийн төв болон бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг БХБЯ-тай хамтран зохион байгуулах.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу батлагдсан ажлын даалгаврын хүрээнд	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн, ерөнхий	Аймгийн төв болон бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна. Хэрэгжилт-50.0 хувь

			боловсруулагдсан байх.	төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлсэн байна.	
Дундаж үнэлгээ					75,8
БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР					
20	Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах”.		Холбогдох хууль, тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу паспортжуулсан болон хүчитгэсэн барилга байгууламжийн тоо	Тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Барилга байгууламжид биет үзлэг хийж, буулган шинээр барихад шаардлагатай төсвийг шийдвэрлэж ажлыг эхлүүлэх мөн Газар хөдлөлтөд тэсвэртэй хүчитгэх шаардлагатай барилга байгууламжийн судалгааг гаргаж шаардлагатай төсвийг шийдвэрлэж ажилласан байна.	Аймгийн төв номын сан, Онцгой байдлын газрын барилга, Цагдаагийн газрын цагдан хорих байр, Прокурорын барилга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны түр саатуулах байр, Хүүхэд гэр бүл, хөгжлийн газар, Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэгийн барилга, Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төв, Бат-Өлзий сумын 100 хүүхдийн дотуур байр, 80 хүүхдийн дотуур байр, Могойтын амны байгаль хамгаалагчийн байр, Үүртийн тохойн байгаль хамгаалагчийн байр, Төвхөны амны харуулын байр, Баян-Өндөр сумын бага сургууль, Зүүнбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургууль, Хархорин сумын Баянголын амны постны барилга, Сант сумын хуучин сургуулийн заал, ерөнхий боловсролын сургууль, Уянга сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Улаан булан ерөнхий боловсролын сургууль, Хужирт сумын төрийн банкны барилгуудад шалгалт хийж ашиглалтын төлөв байдлын талаар дүгнэлт гаргаж тухайн ашиглагч байгуулагуудад тухай бүрт нь хүргүүлж ажилласан. Үүнд ашиглалтын шаардлага хангахгүй 23 барилга байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн барилгын А, Б, В, Г блокод паспортжуулалт хийлгэж байна. Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт-100.0 хувь
21	Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. Тухайлбал; - барилгуудын “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-т “Барилгын		Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдадгүй “ногоон” үзэл баримтлалыг тусгасан барилга болон авч	Орон сууцны болон бусад төрлийн барилгын норм, нормативын баримт бичгийн мөрдүүлэлт, чанар, аюулгүй байдал сайжирсан байна. Мөн	Улсын төсвийн 18, иргэн аж ахуйн нэгжийн 38 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварыг “Барилгын дулаан хамгаалалтын норм”-ын шаардлагыг бүрэн хангасан байхаар, болон “ногоон” барилгын үзэл баримтлал, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай шаардлага, холбогдох норм ба дүрэм,

	дулаан хамгаалалтын норм"-ын шаардлагыг бүрэн хангасан байхаар, болон "ногоон" барилгын үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлэх.		хэрэгжүүлсэн арга хэмжээ, Барилгын норм ба дүрмийн дагуу зураг төсөл боловсруулж, магадлалын дүгнэлтээр баталгаажсан зураг төслийн тоо.	Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын даалгаварт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай шаардлага, холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусгаж, хэрэгжүүлэх, хяналт тавин ажилласан байна.	стандартуудыг тусгаж боловсруулан ажилласан. Мөн "Барилгын чанар, аюулгүй байдал сэдэв"-т Өвөрхангай аймгийн барилгын салбарын "Удирдах ажилтны зөвлөгөөн-2024" 4 дүгээр сарын 12-15-ны хооронд зохион байгуулагдсан сургалтад оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудад Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль норм, дүрэм стандартуудын талаар сурталчилан зохион байгуулсан. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 146 дугаар тушаалаар баталсан "Барилгын дулаан хамгаалалт" БНБД 25-01-20 нормын шаардлагыг хангасан материалыг архитектур төлөвлөлт болон ажлын зургийн даалгаварт тусган ажилласан. Хэрэгжилт-100.0 хувь
22	Ашиглагдаж байгаа олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад шинэчилсэн байдлаар үзлэг, тооллого явуулах.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Аймгийн хэмжээнд нэгдсэн тоог шинэчлэн гаргасан байна.	Аймгийн хэмжээнд "Хот байгуулалтын цахим системд бүртгэгдсэн ашиглагдаж байгаа олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжийн тоо 1207 байна. Хот байгуулалтын мэдээллийн санд оруулж үзлэг тооллого хийх ажил үе шаттай хийгдэж байна. Хэрэгжилт-90.0 хувь
23	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх.		Ашиглалтад орсон барилга байгууламжийн талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлсөн байх	Зөвшөөрлийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, <u>барилга байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлага хангуулж</u> ажилласан байна. Барилгын үйл ажиллагаанд норм, нормативын баримт бичгийг мөрдүүлсэн байна.	Тогтоолын дагуу хэрэгжилтийг хангуулж, 2024 оны жилийн эцсийн байдлаар нийтийн орон сууцны 8, олон нийтийн 5, үйлчилгээний 1, шатахуун түгээх станцын 1, бусад 4 нийт 19 барилга байгууламжид аймгийн Засаг даргын захирамж гаргуулж, ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулаад байна. Ашиглалтад орсон барилга байгууламжийн дэлгэрэнгүй мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж Барилгын хөгжлийн төвд хүргүүлээд байна. Хэрэгжилт-100.0 хувь

24	<p>Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх.</p>		<p>Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд тугуурлан барилгын зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн тоо</p>	<p>Зөвшөөрлийн тухай хууль, Хот Барилгын тухай хууль болон Тогтоолын хэрэгжилтийг хангуулан <u>барилга байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлага хангуулж</u> ажилласан байна. Уг ажлыг тоо баримттайгаар, бодитой тайлагнаж, улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй болон ашиглалтад орсон, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаарх тайланг нэгтгэж ирүүлсэн байна.</p>	<p>Хот байгуулалтын кадастрын шинэчлэгдсэн цахим системийг бүрэн ашиглалтад оруулж, тогтоолын хэрэгжилтийг хангуулан 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Архитектур төлөвлөлтийн даалгавар-42, Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл-32, буулгах зөвшөөрөл-6, сунгалт хийх-3, хүсэлтийн дагуу шийдвэрлэж системд боловсруулалт хийж олгосон. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу нэгдсэн хүснэгтээр гаргаж Барилгын хөгжлийн төвийн anonym_ou@yahoo.com хаягаар хагас, бүтэн жилээр хугацаанд нь хүргүүлсэн. Хэрэгжилт-100.0 хувь</p>
25	<p>Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг ирүүлэх.</p>		<p>Холбогдох мэдээллийн санд тулгуурласан байна. (Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан). Уг ажлыг тоо баримттай, үнэн зөв тайлагнаж, зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээллийг маягтын дагуу ирүүлсэн байх.. (харьяа нутаг дэвсгэр дэх барилга байгууламж)</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг хангуулан барилга байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлага хангуулж ажилласан байна.</p>	<p>Аймгийн Цагдаагийн хуучин барилга, Хөгжимт драмын театр, Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургууль, Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хархорин сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Төгрөг сумын ерөнхий боловсролын сургууль, Политехник коллеж, Хархорин сумын Соёлын төв, Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төв нийт 9 барилгад их болон хэсэгчилсэн засварын ажлын зураг төсвийг гүйцэтгүүлж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар засварын ажлыг гүйцэтгүүлэн байнгын ашиглалтад хүлээн аваад байна. Мөн ерөнхий боловсролын 5 сургууль, аймгийн Цагдаагийн газрын цагдан хорих байр, Төв номын сангийн барилга, Мэргэд сургуулийн хуучин спорт заалны барилгуудад шалгалт хийж ашиглалтын төлөв байдлын талаар дүгнэлт гаргаж, тухайн ашиглагч байгууллагуудад хүргүүлээд байна. Хэрэгжилт-70.0 хувь</p>

26	Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах” заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. 2002 оноос өмнөх болон хойших барилга байгууламжийг ангилаж паспортжуулсан байна.	“Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам” 2023 онд өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2024 оны 09 дүгээр сарын 09-ний А/694 дугаартай Захирамжаар орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Мөн аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 1990 онд баригдсан хуучин 3 барилгад паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргуулахаар “Бүүвэй цагаан барс” ХХК-тай 11 дүгээр сарын 16-ны өдөр гэрээ байгуулан гүйцэтгэлийн ажил эхэлсэн явагдаж байна. Хэрэгжилт-70.0 хувь
27	Барилга, хот байгуулалтын сайдын “Барилга, байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай” 2016 оны 180 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллах.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Тушаалын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Барилга, байгууламжийн хувийн хэргийн бүртгэл сайжирсан байна.	Энэ онд шинээр ашиглалтад орсон 13 барилгын хувийн хэргийг “Барилга, байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай” тушаалын дагуу бүрдүүлж хувийн хэрэг нээсэн байна. Хэрэгжилт-100.0 хувь
28	Барилга, байгууламжийн хувийн хэргийг бүрэн цахимжуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх.		Цахим мэдээллийн санд оруулсан барилга байгууламжийн хувийн хэргийн тоо.	Тушаалын хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Барилга, байгууламжийн хувийн хэргийн бүртгэл бүрэн цахимжсан байна.	Аймгийн хэмжээнд 1207 барилгын хувийн хэргийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэж бүрэн цахимжуулсан. Энэ оны жилийн эцсийн байдлаар шинээр ашиглалтад орсон 13 барилгын хувийн хэргийг цахимжууллаа. Хэрэгжилт-100.0 хувь
29	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтын дагуу барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг албадан буулгах арга хэмжээ авах, мэдээллийг БХБЯ-нд хүргүүлж ажиллах.		Буулгасан барилга байгууламжийн тоо	Хүн амын эрүүл, аюулгүй байх нөхцөл бүрдэнэ.	Энэ онд барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй албадан буулгах ажил хийгдээгүй байна. Барилгын бетоны марк нь зургийн даалгавар болон ажлын зураг төсөлд тусгагдсан хэмжээнд хүрээгүй Баруунбаян-Улаан суманд баригдаж байгаа Соёлын төвийн өргөтгөлийн барилга, Арвайхээр суманд баригдаж байгаа 10 давхар орон сууц, Хархорин суманд баригдаж байгаа 10 давхар 2 орон сууц, Хужирт суманд баригдаж байгаа 25 айлын орон сууцны барилгын ажлыг Улсын байцаагчийн дүгнэлтээр зогсоон хөндлөнгийн дүгнэлт гаргуулан хүчитгэл хийлгэх арга хэмжээг авхуулан ажиллаж байна.

					Хэрэгжилт-100.0 хувь
30	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг хангуулж ажиллах.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Барилгын ажиллагааны үйл осол буурсан байна.	Барилгын ажлын эхлүүлэх зөвшөөрлийг олгохдоо талбайд ажиллах Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, талбайн инженерийн тушаалыг гаргуулан талбайд ажиллуулах шаардлагыг тавин баримт бичгийн бүрдлийг хангуулан аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэн ажиллаж байна. Орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй 40 гаруй аж ахуйн нэгжийн 55 инженер техникийн ажилтныг хамруулж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 4 дүгээр сард зохин байгуулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд барилга байгууламжийн угсралтын үйл ажил гүйцэтгэх явцад ажлын байрны осол 1 гарсан байна. Хэрэгжилт-90.0 хувь
31	Барилгын материалын лабораторийн итгэмжлэл, тоног төхөөрөмжийн хүчин чадал, ашиглалт, мэргэжилтэй боловсон хүчний ажилласан жил, шинжээчийн сургалтад хамрагдсан эсэх мэдээлэл, сорил шинжилгээний тоо хэмжээ, дүгнэлт бүхий тайланг ирүүлж ажиллах.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Судалгаа мэдээллийн нэгдсэн бүртгэлтэй болсон байна.	Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааны тайлан мэдээг жилийн эцсийн байдлаар гарган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Барилгын хөгжлийн төвд 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын №563 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна. Хэрэгжилт-100.0 хувь
32	Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулсан байна.	39 сая	Шинээр болон шинэчлэн угсарсан тоног төхөөрөмжийн тоо	Барилгын материалд хийх шинжилгээний нэр төрөл нэмэгдэж, барилгын материалын чанар сайжирна.	Барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор техник хяналтын зардлаас нийт 39,1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Бетоны бат бэхийг тодорхойлогч шмитын алх, хэт авианы багаж, бетоны агаарын агууламж тодорхойлогч багажуудыг хүлээн авч ашиглаж байна. Хэрэгжилт-100.0 хувь
33	"Аймгуудын барилгын материалын лабораторийн ажилчдыг чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах.		Сургалтад хамруулсан албан хаагчдын тоо	Барилгын материалд хийх шинжилгээний нэр төрөл нэмэгдэж, барилгын материалын чанар сайжирна.	Барилгын хөгжлийн төвийн Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид, лабораторийн лаборантуудыг чадавхжуулах дадлагажуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол авах ажлын хүрээнд лаборант шинжилгээний үр дүнг боловсруулах,

					бетоны орц найрлага тогтоох цонхны шинжилгээ хийж чадавхжуулах, дадлагажуулах, мэргэжил арга зүйн дадлагад 2 албан хаагч хамрагдсан. 2024 оны 08 дугаар сарын 16-18-нд өдрүүдэд “Монголын бетоны холбоо”, Шинжлэх ухаан технологийн их сургууль хамтран зохион байгуулсан Азийн бетоны 10 дугаар чуулга уулзалт сургалтанд 3 албан хаагч, 2024 оны 11 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Хасах градуст хэрхэн бетон тээвэрлэх” болон талбай дээр орчныг бэлтгэж бетон авч буй практик дадлагад 1 албан хаагч, 2024 оны 11 дүгээр сарын 26-29-нд зохион байгуулагдсан MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандарт хэрэгжүүлэх арга зүй, дотоод аудитын сургалтанд 2 албан хаагчийг хамруулан чадавхжуулан ажиллаж байна. Хэрэгжилт-100.0 хувь
34	Барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүчин чадал, ажиллах хүчний мэдээлэл, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ, тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй эсэх талаар дэлгэрэнгүй судалгаа гарган хагас, бүтэн жилээр “БХТ” ТӨААТҮГ-т ирүүлэх.		Барилгын материал үйлдвэрлэдэг хуулийн этгээдүүдийн үйлдвэрийн хүчин чадал, борлуулалтын орлого.	Бодлого төлөвлөлтөд шаардагдах суурь судалгаатай болсон байна.	Барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүчин чадал, ажиллах хүчний мэдээлэл, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ, тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй эсэх талаар дэлгэрэнгүй судалгааг хагас, бүтэн жилээр “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-д албан бичгээр хүргүүлэн ажилласан. Хэрэгжилт-100.0 хувь
35	Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын орд илэрцийн судалгаа гаргах, тухайн оны эрэлт нийлүүлэлтийн судалгааг гаргаж, хагас, бүтэн жилээр “БХТ” ТӨААТҮГ-т ирүүлэх.		Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд илэрцийн тоо	Барилгын ажилд шаардагдах эрэлт, нийлүүлэлтийг судалгааны аргачлалд тулгуурласан байх. (харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд)	Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын 4 тусгай зөвшөөрлийн нийт 122.1 га, хайгуулын 9 тусгай зөвшөөрлийн нийт 1082 га талбай уул уурхайн кадастрын системд бүртгэлтэй байна. Дээрх аж ахуйн нэгжүүд хайгуулын төлөвлөгөө батлуулахдаа архелог, палентологийн судалгааг эрх бүхий байгууллагаар хийлгүүлж дүгнэлт гаргуулсаны дараа бусад хайгуулын ажил явуулахаар зөвлөгөө өгч, ажиллаж байна. Энэ онд түгээмэл тархацтай ашигт малтмалын

					хайгуулын 3 тусгай зөвшөөрөл олгосон. 2023 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан Зулбуян-Ундрах ХХК энэ онд ашиглалт явуулсан, Өв-Идэр ХХК менежментийн төлөвлөгөө батлуулж шинээр ашиглалт явуулахад бэлэн болсон байна. Мөн тоосгоны шаварын 2 уурхай ажиллаж байна. Аймгийн хэмжээнд бүтээн байгуулалтад ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмал эрэлт их, нийлүүлэлт бага байна. Хэрэгжилт-90.0 хувь
36	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг Тохирлын үнэлгээнд хамруулан “Тохирлын гэрчилгээ” авах шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулах		Тохирлын гэрчилгээ авсан бүтээгдэхүүний тоо	Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”-ын 3.1 заалтын хэрэгжилт хангагдаж, орон нутагт бүтээгдэхүүний чанар дээшилнэ.	Тохирлын гэрчилгээнд хамрагдсан барилгын материал үйлдвэрлэгч 9 аж ахуйн нэгж байна. Үүнээс Тохирлын гэрчилгээний хугацаа дуусаагүй 4 аж ахуйн нэгж байна. Харин тохирлын гэрчилгээний хугацаа дууссан сунгуулах хүсэлтэй 5 аж ахуйн нэгж байна. Энэ онд шугам сүлжээний бетон кольцо 1, хөнгөн блок 2 төрлөөр шинээр тохирлын гэрчилгээ авахаар материалыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлсэн. Хэрэгжилт-100.0 хувь
37	Барилгын салбарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” аяныг төлөвлөх, аяныг үр дүнтэйгээр зохион байгуулах, хэрэгжилтийн тайлан хүргүүлэх.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Аймгийн хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” аян зохион байгуулсан байна	“Монголын цахим институт” хариуцлагатай хязгаарлагдмал компанитай хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”-н 12 цагийн сургалт зохион байгуулж орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй 40 гаруй аж ахуй нэгжийн 55 инженер техникийн ажилтныг хамруулж “СЕРТИФИКАТ” олгов. Тус сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шинэчилсэн хууль, дүрэм, журам, стандарт, газар шороо болон хязгаарлагдмал орчны үеийн аюулгүй ажиллагаа, нэг бүрийн хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах, ач холбогдол, осолдогсдод үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, өндрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан

					бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх сэдвүүдээр зохион байгуулав. Хэрэгжилт-100.0 хувь
38	Үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа байгууллага аж ахуй нэгжүүдэд барилга угсралтын талбайг камержуулах үүрэг чиглэлийг өгч хэрэгжилтийг хангуулж ажиллах.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Барилга угсралтын үеийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд баригдаж байгаа 25, хувийн хэвшлийн 14 орон сууцны төслийн талбайн үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор барилга угсралтын талбайг камержуулах ажлыг бүрэн зохион байгуулж ажилласан. Хэрэгжилт-100.0 хувь
39	Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг "Төслийн удирдлагын арга зүйн заавар" MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийг тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Барилга угсралтын аж ахуйн нэгж, байгууллагууд "Төслийн удирдлагын арга зүйн заавар" MNS:ISO 21500 стандарт нэвтрүүлсэн байх	Орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 1 аж ахуйн нэгжид "Төслийн удирдлагын арга зүйн заавар" MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийг тогтолцоог нэвтрүүлэхээр талаар, 2024 оны 04 дүгээр сарын 20-21-ний хооронд орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулж буй 28 аж ахуйн нэгж байгууллага, 38 инженер техникийн ажилчдыг хамруулсан зөвлөгөөнд 2 цагийн "Төслийн удирдлагын арга зүйн заавар" MNS:ISO 21500 стандартыг барилгын талбайд нэвтрүүлж ажиллахын давуу тал болон хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө өгч, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэрэгжилт-100.0 хувь
40	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцыг бодлого үйл ажиллагаандаа тусгах, хэрэгжилтийг хангах, тайланг хүргүүлэх.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.	"Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцын холбогдох зүйл заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.	"Хөгжлийн төлөө барилгачдын нэгдсэн холбоо" ТББ-аас зохион байгуулсан "Барилгачдын зөвлөгөөн-2024" оролцон барилга угсралт, засварын ажлыг гүйцэтгэхдээ барилгын талбайн аюулгүй байдлын дээд зэргээр анхаарч үйл ажиллагаандаа "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцын зүйл заалтыг мөрдөж ажиллах үүрэг өгч, зүйл заалт бүрээр тайлбарлан сургалт зохион байгуулж ажилласан тайланг хүргүүлсэн. Хэрэгжилт-100.0 хувь

41	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахтай холбогдуулан төлөвлөж буй барилгын газрын асуудлуудыг шийдвэрлэх.		Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна.	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл арга хэмжээтэй уялдуулан шаардлагатай газрын асуудлыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж шийдвэрлэж, газрын гэрчилгээг гаргасан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх барилгуудын газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган шаардлагатай техникийн нөхцөлийг олгох асуудлыг шийдвэрлэсэн. Нийт 25 барилгын газрын асуудал шийдвэрлэгдэж, зураг төсөл нь хийгдсэн. 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, санал тусгасан барилга угсралтын ажлуудын газрын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Хэрэгжилт-90.0 хувь
42	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахтай холбогдуулан шаардлагатай техникийн нөхцөлийн судалгаа хийж олгох асуудлыг шийдвэрлэх.		Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна.	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл арга хэмжээтэй уялдуулан шаардлагатай техникийн нөхцлийг олгох асуудлыг шийдвэрлэх.	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 25 барилга, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2 барилга угсралтын архитектур төлөвлөлтийн даалгаварыг боловсруулсан. Дээрх төсөл арга хэмжээтэй уялдуулан ажлын зураг төсөлд шаардлагатай техникийн нөхцлийн олголт хийгдээд байна. Хэрэгжилт-100.0 хувь
43	Барилга байгууламжийн зураг төслийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох норм, дүрмийн дагуу тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлах, тайлан мэдээг улирал тутам ирүүлэх.		Батлагдсан Барилга байгууламжийн зураг төслийн архитектур төлөвлөлтийн даалгаврын тоо	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж буй барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг хангуулж баталсан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 25 барилга, иргэн, аж ахуйн нэгжийн 38, нийт 63 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварыг холбогдох норм, дүрмийн дагуу тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хянан батлалаа. Хэрэгжилт-100.0 хувь
44	Төлөвлөж буй барилга байгууламжийн төсөл арга хэмжээний зургийн даалгаварыг холбогдох норм, дүрмийн		Батлагдсан зургийн даалгавар тоо	2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх техник,	"Сумын хөгжил төсөл"-ийн хүрээнд 8 суманд шинээр барих гадна ус хангамж, ариутгах татуурга, дулааны шугам сүлжээний барилга

	дагуу тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж батлах, тайлан мэдээг улирал тутам ирүүлэх.			эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж буй барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг хангуулж баталсан байна.	байгууламж, 11 чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлын зураг төсөв боловсруулах даалгаварыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, холбогдох норм, дүрмийн дагуу тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөж баталлаа. Хэрэгжилт-100.0 хувь
45	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсроход шаардлагатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.1.2)		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Аймгийн тусгай хэрэгцээтэй сургуулийн сурагчдийн хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр дэмжлэг үзүүлсэн байна.	Арвайхээр сумын 13 дугаар багт улсын төвийн 4.261,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд ашиглалтад оруулахаар Тусгай хэрэгцээтэй 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажил хийгдэж байгаа бөгөөд 35 хувийн гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилт-70.0 хувь
46	Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, салбарт тэдний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд холбогдох арга хэмжээг авах. /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 17 дугаар зүйл/		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлд 12 дугаар сарын 15-20-ны хооронд тайланг хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн Арвайхээр суманд улсын төсвийн 4,209.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд ашиглалтад оруулахаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга шинээр баригдаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 25 хувьтай байна. Хэрэгжилт-90.0 хувь
47	Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын 2.2.5. “эх орны эрдэс, түүхий эдийн нөөцийг үр ашигтай, зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын чиг баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх”		Шинээр ашиглалтад орсон барилгын материалын үйлдвэрлэлийн тоо	Аймгийн бүтээн байгуулалтад шаардлагатай үндсэн нэр төрлийн барилгын материалыг орон нутгаас хангах	Аймгийн хэмжээнд шинээр байгуулах үйлдвэрийн санал ирээгүй байна. Хэрэгжилт-30.0 хувь

	зорилтын хүрээнд орон нутагт шинээр байгуулах шаардлагатай барилгын материалын үйлдвэрийн төслийг дэмжиж ажиллах				
Дундаж үнэлгээ					92,5
НИЙТИЙН АЖ АХУЙ, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР					
48	Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл, мэдээллийг цахим хэлбэрт оруулж, тухай бүр баяжилт, хөтлөлтийг гүйцэтгэх		Бүртгэлд шинээр болон шинэчлэн бүртгэгдсэн Сууц өмчлөгчдийн холбооны тоо	Үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбоодын талаарх бүртгэл, мэдээллийг мэдээллийн сангийн бүртгэл хөтлөгдөж, баяжилт хийгдсэн байна.	Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа Найрамдал, Цэлмэг, Онги-Өргөө гэсэн 3 Сууц өмчлөгчдийн холбооны мэдээллийг www.mcis.gov.mn цахим бүртгэл мэдээллийн санд бүртгүүлээд байна. Шинээр 1 Сууц өмчлөгчдийн холбоо байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлэхээр холбогдох материалыг бүрдүүлэн ажиллаж байна. Бүртгэл мэдээллийн цахим системд сууц өмчлөгчдийн холбооны мэдээллүүдийг шинэчилэн оруулсан. Хэрэгжилт-100.0 хувь
49	Шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшинд хамаарах инженерийн түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж авах, шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулах ажлыг шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулах.		орон нутгийн өмчид шинээр бүтгэж авсан шинээр нийтийн зориулалттай орон сууцны байшинд хамаарах инженерийн түгээх сүлжээний мэдээлэл	Түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулсан байх.	Шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшинд хамаарах инженерийн түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэн Арвайхээр суманд “Онги-Ус суваг” ТБОНӨО ХХК, Хархорин суманд “Хархорин-Ус суваг” ОНӨААТҮГ-т тус тус хариуцуулан ажиллаж байна. Хэрэгжилт-100.0 хувь
50	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, 17, 18, 19 дүгээр зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлэх.		Хуулийн хэрэгжилтийн хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	1.Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт; 2.Хуулийн 17, 18 дугаар зүйлийн заалтууд; 3.Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг тус тус хэрэгжүүлсэн байна.	Аюулгүй ундны усаар хангагдсан хүн амын тоо 3685, ариун цэврийн байгууламжид холбогдсон хүн амын тоо 3281 байна. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй “Онги ус суваг” ТБОНӨО ХХК “Хархорин ус суваг” ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор үйлдвэрлэлийн осол гэмтэл гараагүй үйл ажиллагаа хэвийн, инженер техникийн ажилчид тогтвор

				<p>4. Инженер, техникийн ажилтан, ажиллагсдын тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байна.</p> <p>5. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулсан байна.</p> <p>6. Ус хангамжийн эх үүсвэрийн байгууламжид унд ахуйн усыг халдваргүйжүүлэх төхөөрөмж, ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжид цэвэрлэгдээд гарч буй усыг халдваргүйжүүлэх төхөөрөмжийг орон нутгийн хөрөнгөөр суурилуулсан байна.</p> <p>7. Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг газрын кадастрын мэдээллийн санд оруулсан байна.</p> <p>8. Монгол Улсын Их хурлын 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүн амын унд, ахуйн усны чанарын асуудлыг бодлогын түвшинд авч үзэн, хэрэгжүүлэх</p>	<p>суурьшилтай ажиллаж байна. Хархорин сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх зургийн даалгаврыг боловсруулж Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулаад байна. Арвайхээр сумын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид унд ахуйн усыг давсны уусмалаар халдваргүйжүүлэх төхөөрөмжийг орон нутгийн хөгжлийн сангийн 72,1 сая төгрөгөөр суурилуулсан. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжид цэвэрлэгдээд гарч буй усыг халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилагдсан. Хужирт сумын ундны усны цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж “Онги ус суваг” ТБОНӨО ХХК-д хариуцуулаад байна. Тус цэвэрлэх байгууламжид цэвэрлэгдээд гарч буй усыг халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулсан. Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг газрын кадастрын мэдээллийн санд оруулах ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт-90.0 хувь</p>
51	УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-		1.Шинээр иж бүрэн инженерийн	1.Төвлөрсөн шугам сүлжээтэй сумдын гэр хорооллын айл өрхийг ус,	Сумын хөгжил арга хэмжээний хүрээнд Хужирт, Бат-Өлзий, Уянга сумдад инженерийн дэд бүтэц шугам сүлжээний

	<p>ийн 6.2.7-д “Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>		<p>дэд бүтцийн хангамжтай болсон сумдын тоо 2.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан сумдын тоо 3.Шинээр төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо.</p>	<p>дулаан, ариутгах татуургын шугам сүлжээнд холбосон байна. 2.“Сумын хөгжил” төслийн хүрээнд 1-2 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан байна.</p>	<p>шинэчлэлийн ажил хийгдэж байна. Хужирт сумын шугам сүлжээний угсралтын ажил дуусч гүйцэтгэгчээс улсын комисс ажиллуулах хүсэлтийг ирүүлсэн. Уянга сумын дулааны 1 дүгээр ээлжийн угсралтын ажил дуусч, тухайн хэсэгчилсэн ажлын хувьд улсын комисс ажиллуулах хүсэлтийг ирүүлээд байна. Мөн Уянга сумын цэвэр усны гүний худгийн барилга угсралт, усан сангийн барилгын угсралт, цэвэр усны дамжуулах, түгээх, олборлох шугам, бохир усны шугам сүлжээний угсралтын ажлууд бүрэн хийгдэж дууссан. Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу цэвэрлэх байгууламжийн байршлыг өөрчлөх хүсэлтийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлээд байна. Бат-Өлзий сумын инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн угсралтын ажил 85.0 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Энэ онд шинээр Нарийнтээл суманд “Сумын хөгжил инженерийн шугам сүлжээ” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 17.0 хувьтай байна. Арвайхээр суманд албан байгууллага, айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын хүрээнд энэ онд улсын төсвийн 12,8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 3 багц ажил хийгдэж байна. 1 дүгээр багц 1, 9 дүгээр хорооллын инженерийн шугам сүлжээ, 2 дугаар багц 3, 8 дугаар хорооллын инженерийн шугам сүлжээ, 3 дугаар багц Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ гэсэн 3 багцын хүрээнд тус тус хийж гүйцэтгэж байна. Ажлын нийт гүйцэтгэл 20-50 хувьтай байна. Энэ онд аймгийн хэмжээнд 1088 айл өрх шугам сүлжээд холбогдоод байна. Хэрэгжилт-90.0 хувь</p>
--	--	--	---	--	--

52	Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, биелэлтийг гаргаж ирүүлэх.	<p>1.Сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулсан сумдын тоо</p> <p>2.Шинээр бий болсон болон үйл ажиллагаа нь тогтмолжсон нийтийн халуун усны төвийн тоо</p> <p>3.Хөрсний бохирдолгүй нүхэн жорлонгийн тоо</p> <p>4.Сумын нийтийн аж ахуйн байгууллагад ажиллах инженер техникийн ажилтан бэлтгэн, сургаж дадлагажуулсан хүний тоо.</p> <p>5.ХСУХАТАҮЗЗ-өөр цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулсан сумдын тоо.</p>	Иргэд мэргэжлийн байгууллагаар ус, дулаан хангамж, ариутгах татуурга, нийтийн халуун усаар үйлчлүүлэх нөхцөл бүрдэж, хөрсний бохирдол буурсан байна.	<p>Аймгийн хэмжээнд сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулсан 7 сум байна. Аймгийн хэмжээнд нийт 35 халуун усны газар үйл ажиллагаа явуулж байна. Арвайхээр суманд “Нүхэн жорлон угаадасны нүх, Техникийн шаардлага MNS 5924: 2015” стандартын шаардлагад нийцсэн 337 өрх сайжруулсан нүхэн жорлонтой болсон. Шинээр 2024 онд Арвайхээр суманд 712,8 сая төгрөгийн санхүүжилтээр 10 багт нийт 200 ширхэг эко ариун цэврийн байгууламж байгуулахаар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажил хийгдэж байна. Сумын нийтийн аж ахуйн байгууллагад ажиллах 4 инженер техникийн ажилтан бэлтгэн, сургаж дадлагажуулсан. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөр цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулах талаар Баянгол, Төгрөг, Хайрхандулаан, Уянга, Бат-Өлзий, Хужирт сумдад судалгаа хийгдээд байна.</p> <p>Хэрэгжилт-90.0 хувь</p>
----	--	---	--	--

53	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг хангах.		1.Ундны усны судалгаанд хамрагдсан сумдын тоо 2.Ундны усны мэдээллийн санд бүртгэгдсэн усны эх үүсвэрийн тоо	Аймгийн хэмжээнд ундны усны чанарын судалгааг хийлгэж, үүнд үндэслэн ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг шинэчлэн сайжруулсан байна	Аймгийн хэмжээнд сумдын усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг 2023 А/40 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Нийт 19 сумын төвийн нутагт орших гүний худаг, ус түгээх байр, булаг, голын усны 55 сорьц цуглуулан физик-хими, бичил элемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг тодорхойлж сум тус бүрээр нь нэгтгэн дүгнэж зөвлөмж боловсрууллаа. Арвайхээр суманд 1 дүгээр улиралд ундны эх үүсвэрийн гүний худагт шинжилгээ хийгдсэн бөгөөд дүгнэлтээр унданд хэрэглэхэд хэвийн гэсэн дүгнэлт гарсан. Хэрэгжилт-100.0 хувь
54	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хүрээнд сумдын усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулж, Хууль зүйн яамны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх		усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулсан сумдын тоо	Бүх сумдын усны үйлчилгээний тарифыг ХСУХАТАҮЗХ-ны тогтоолоор батлуулах	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөр сумдын цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулах талаар судалгаа хийгдэж байна. Хэрэгжилт-50.0 хувь
55	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.	712 сая	Хэрэглээнд нэвтрүүлсэн нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага. MNS 5924: 2015” стандартын шаардлагын хангасан нүхэн жорлон, угаадсны нүхний тоо	1.Аймгийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тооллого зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэж үйл ажиллагааг тогтмолжуулсан байна. 2.Судалгаанд үндэслэн “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага. MNS 5924: 2015” стандартын шаардлагад нийцсэн жорлонг суурилуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Аймгийн хэмжээнд хөрс бохирдуулагч нүхэн жорлон 31,220 байна. Арвайхээр суманд “Нүхэн жорлон угаадасны нүх, Техникийн шаардлага MNS 5924: 2015” стандартын шаардлагад нийцсэн 337 өрх сайжруулсан нүхэн жорлонтой болсон. Шинээр 2024 онд Арвайхээр суманд 712,8 сая төгрөгийн санхүүжилтээр 10 багт нийт 200 ширхэг эко ариун цэврийн байгууламж байгуулахаар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажил хийгдэж байна. Хэрэгжилт-90.0 хувь

				3.Хэрэгжилтийн мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр ирүүлсэн байна.	
56	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хэрэгжүүлэх		Сургууль, цэцэрлэг, дотуур байрны шинээр баригдсан ариун цэврийн байгууламжийн тоо	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солигдсон байна.	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын хүрээнд Төгрөг, Гучин-Ус, Сант, Баянгол, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Уянга, Уянга сумын Жаргалант баг, Тарагт, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Арвайхээр, Хархорин сумдад төсөл хэрэгжиж ашиглалтад орсон. Хужирт, Бат-Өлзий сумын цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажил дуусч, дизель генератор суурилуулах ажил үлдсэн бөгөөд нийт 95 хувийн гүйцэтгэлтэй байна. Есөнзүйл, Бүрд сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын гүйцэтгэгчийг дахин сонгон шалгаруулахаар батлагдсан зураг төсвөөс хийгдсэн ажлыг хасуулан дахин хяналтаар оруулан Боловсролын яамнаас худалдан авах ажиллагааг зохин байгуулаад байна. Хэрэгжилт-90.0 хувь
57	Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдлийн үнэлгээ хийх.		Эрсдлийн үнэлгээ-1 Ус бохирлуулагч үйлдвэрүүдийн ашиглалтал оруулсан урьчдлан цэвэрлэх байгууламжийн тоо	ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу 6 модуль бүхий төлөвлөгөөг боловсруулж эрсдлийн үнэлгээ хийгдсэн байна. Мөн ус бохирдуулагч үйлдвэрүүдийг урьчдлан цэвэрлэх байгууламжтай болгох.	Өвөрхангай аймагт Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний 2 ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулж байна. 2024 онд үерт автах эрсдэлтэй ариутгах татуургын 100, дулааны 20-30 худаг засварлахаар судалгааг гаргасан. Аймгийн Засаг даргын захирамжаар ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдлийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулагдан аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдлийн үнэлгээ хийгдэж байна. Хэрэгжилт-100.0 хувь

58	“Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” Засгийн Газрын 2012 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Төсөвт тусгагдсан хөрөнгийн хэмжээ	Арвайхээр суманд байгаа ус түгээх байруудын 70 хувь нь хувьчилагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2012 оны 209 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй. Хэрэгжилт-30.0 хувь
59	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээ, түүний санхүүжилтийн саналыг тухайн сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн өнөөгийн байдал, боловсруулж батлуулсан ТЭЗУС, ТЭЗҮ, зураг төсөлд үндэслэн тооцож ирүүлж байх. Ингэхдээ сум, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний судалгаа хийх, зураг төслийг боловсруулах, зөвшилцөх шатанд мэргэжлийн байгууллагуудын саналыг сайтар тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн байх.		Багц саналын тоо	Шаардагдах хөрөнгө санхүүжилтийн тооцоо, судалгаа бүхий саналыг боловсруулан БХБЯ-нд ирүүлсэн байна.	Энэ онд улсын төсвийн 6,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нарийнтээл суманд сумын хөгжил инженерийн дэд бүтцийн хангамж шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж байгаа бөгөөд 17 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй 8 сумдыг 2025 оны сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах чиглэл өгөөд байна. Үүнтэй холбогдуулан инженерийн шугам сүлжээгүй 8 суманд инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулахаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт худалдан авах ажиллагааг зохион байгуулаад байна. Зураг төсөл боловсруулагдсаны дараагаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналд тусгуулахаар төлөвлөөд байна. Хэрэгжилт-90.0 хувь
60	Аймаг, сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, үерийн хамгаалалтын далан, суваг г.м/ тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний түвшингийн өнөөгийн байдлыг /чанар, насжилтыг/ тодорхойлсон судалгаа, мэдээллийг БХБЯ-ны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлэх.		Судалгаанд тусгагдсан инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний	Аймаг, сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, үерийн хамгаалалтын далан, суваг г.м/ тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний түвшингийн өнөөгийн байдлыг /чанар,	Аймгийн хэмжээний ус, дулаан, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Цэвэрлэх байгууламж, ус, дулаан, ариутгах татуургын тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт үйлчилгээний төлөв байдал, насжилтын судалгааг гарган Барилгын хөгжлийн төвд s.ankhtuya@barilga.gov.mn мэйл хаягаар 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр

			хугацааны талаарх мэдээлэл	насжилтыг/ тодорхойлсон судалгаа хийгдсэн байна.	хүргүүлсэн. Усны эх үүсвэрийн мэдээллийн судалгааг хагас, бүтэн жилээр гарган Барилгын хөгжлийн төвд s.ankhtuya@barilga.gov.mn мэйл хаягаар хүргүүлсэн. Инженерийн дэд бүтцийн судалгааг гарган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуй, бодлого зохицуулалтын газарт ulziutas@mudch.gov.mn мэйл хаягаар хүргүүлэн ажилласан. Хэрэгжилт-100.0 хувь
61	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, сумдад шинээр болон шилжиж хийгдэхээр тусгагдсан Инженерийн хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт, үерийн хамгаалалтын далан, сувгийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, ажлын үр дүнг тайлагнах.		Ашиглалтад өгсөн шугам, сүлжээний уртын хэмжээ.	Инженерийн хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна. Аймаг бүрт иргэдийг орон сууцжуулах төсөл хэрэгжих, хүн амын ажиллаж, амьдрах таатай нөхцөл, хот, суурин газар өргөжин тэлэх боломж бүрдсэн байна. Ажлын үр дүнг тайлагнасан байна.	“Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл арга хэмжээний хүрээнд Бат-Өлзий суманд шугам сүлжээний ажлын гүйцэтгэл 85 хувьтай, Хужирт суманд ажил 98 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Гэр хорооллын шугам сүлжээ (Өвөрхангай, Арвайхээр сум) төсөл арга хэмжээний хүрээнд 12,8 тэрбум төгрөг улсын төсөвт тусгагдаж, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 409 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тушаалаар орон нутагт худалдан авах ажиллагаа зохион багуулах эрх нь шилжиж ирж, энэ онд 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан. Дээрх төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/227 дугаар захирамжаар 3 багцад хуваан худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан, гэрээ байгуулан дараах ажлууд хийгдэж байна. 1 дүгээр багцын ажил 3, 8 дугаар багт, 2 дугаар багцын ажил 1, 9 дүгээр багт, 3 дугаар багцын ажил Гэр хорооллын шугам сүлжээ Арвайхээр сумын Залуус, Од хороолол, 2, 3, 8, 1, 9, 13-р багуудад шинээр шугам сүлжээний ажил хийгдэж байна. Ажлын нийт гүйцэтгэл 25-30 хувьтай байна. Хэрэгжилт-100.0 хувь

62	Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 150-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах .		Төслийн хэмжээнд ИШС-д холбогдсон айл өрхийн тоо	Аймгуудын хэмжээнд гэр хорооллын 150 өрх инженерийн сүлжээнд холбогдож, орон сууцны нөхцөл нь сайжирсан байна	Энэ оны байдлаар аймгийн хэмжээнд гэр хорооллын 178 айл өрх инженерийн шугам сүлжээнд холбогдохоор техникийн нөхцөл гаргуулсанаас 85 айл өрх инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдоод байна. Мөн аймгийн хэмжээнд 212 айлын 8 орон сууц инженерийн шугам сүлжээнд шинээр холбогдоод байна. Хэрэгжилт-100.0 хувь
63	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.15-д хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт нь аймгийн чиг үүрэгт хамаарах тул үерийн гамшгаас хамгаалах далан, сувгийг төлөвлөх, ашиглах, ашиглалтад байгаа үерийн далан суваг, борооны ус зайлуулах сувгийн засвар үйлчилгээ, лаг хагшаасыг тогтсон хугацаанд цэвэрлэдэг байх, цаашид ашиглалт, үйлчилгээ хариуцах байгууллагыг тодорхой болгон, үерийн эрсдэлээс сэргийлэх.	1,4 тэрбум	Үерийн далан, суваг, уртын хэмжээ	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийг нэмэгдүүлэх, засвар үйлчилгээ, цэвэрлэгээг хийснээр иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна.	Энэ онд Нарийнтээл сумын 4 км үерийн далан сувгийн ажлын зураг төслийг гүйцэтгүүлэн хүлээн авсан. Арвайхээр сумын гэр хорооллын иргэдийн үерээс хамгаалах зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн 1,46 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эмтийн сайр орчимд урсац тохируулгын усан сан байгуулах ажлыг гүйцэтгүүлэн байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус байгууламжийн ашиглалт, арчилгаа, цэвэрлэгээний асуудлыг хариуцаж ажиллахыг Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөөд байна. Мөн аймгийн төвийн ашиглалтад байгаа үерийн далан суваг, борооны ус зайлуулах сувгийн засвар үйлчилгээ, лаг хагшаасыг тогтсон хугацаанд цэвэрлэх ажлыг Арвайхээр сумын “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ хариуцан ажиллаж байна. Хэрэгжилт-90.0 хувь
64	Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэл хийх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах,		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Аймгийн хэмжээнд “Байр зүйн дэвсгэр тоон зураг, дэд бүтцийн мэдээллийн сан” болон “Хот байгуулалтын мэдээллийн сан”-д хот суурин газруудын газар дээрх болон газар доорх инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний мэдээллээр тогтмол	Ашиглалтанд орсон барилга байгууламжуудын гадна шугам сүлжээг хот байгуулалтын цахим системд оруулан баяжилтыг хийж байна. Энэ онд дулааны 789,13 м шугам, 16 худаг, цэвэр усны 718,65 м шугам, 6 худаг, бохир усны 1173,32 м шугам, 51 худаг, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах газар доорх 173,61 м кабель, агаарын 369,8 м шугам, 8 тулгуур, нам хүчдэлийн газар доорх 990,81 м кабель, агаарын 40,49 м

				баяжилт хийх ажлыг зохион байгуулж бүтэн жилээр тайлагнасан байна.	шугам, 1 тулгуур, холбооны газар доорх 607,61 м кабель шугам, 13 холболтын худаг, агаарын 3286,3 м шугам, 57 тулгуур, газар доорх шилэн кабель 27036,68 м, агаараар 6186,34 м шилэн кабель шугамыг “Байр зүйн дэвсгэр тоон зураг, дэд бүтцийн мэдээллийн сан” болон “Хот байгуулалтын мэдээллийн сан”-д оруулсан байна. Хэрэгжилт-100.0 хувь
65	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд оруулж, мэдээллийн сангуудыг нэгтгэж, хамгаалалтын зурваст газар олгогдохгүй байх нөхцлийг бүрдүүлэн, ажлыг зохион байгуулах		Орон нутгийн өмчид шинээр бүртгэсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, мэдээллийн санд оруулсан шугам сүлжээний урт	Хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна.	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүсчлэлийг сумдын даамлуудаар дамжуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар санал оруулан батлуулсан. Одоогоор Гучин-Ус, Сант, Хайрхандулаан сумд хамгаалалтын зурвас тогтоолгосон. Хэрэгжилт-90.0 хувь
66	Аймгийн хэмжээнд үерийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрэмбийг тогтоох, барьж байгуулах шаардлагатай үерийн хамгаалалтын барилга байгууламжийг төлөвлөж хэрэгжүүлэх, иргэдийг үерийн эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах.		Үерийн суваг, далан, уртын хэмжээ	Үерийн эрсдэлийн үнэлгээ хийлгэж шаардлагатай үерийн хамгаалалтын барилга байгууламжийг нэмэгдүүлж, иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна.	Өвөрхангай аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/486 дугаар захирамжаар үер, усны эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг байгуулан аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Ус, цаг уур орчины шинжилгээний төв, Арвайхээр хотын захиргаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Өвөрхангай АЗЗА” ТӨХК, Эрүүл мэндийн газруудтай хамтран үерээс хамгаалах хамгаалалтын далан, зам, гүүрний ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулж, далан, суваг шуудуу цэвэрлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах талаар холбогдох байгууллагуудад албан мэдэгдэл өгч ажиллалаа. Хэрэгжилт-90.0 хувь

67	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах.		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	<p>1.Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.</p> <p>2.Орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий шинэ цэвэрлэх байгууламжид ажиллах инженер, техникийн ажилтан ажиллагсдыг сургаж дадлагажуулах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх давтан сургалтад хамруулж, инженер техникийн ажилтны нөөцтэй болсон байна.</p> <p>3.Цэвэрлэх байгууламжид ажиллахаар сургагдсан инженер, техникийн ажилтнуудыг тогтвор сууршилтай ажиллах нөхцлөөр ханган ажиллана.</p> <p>4. Цэвэрлэх байгууламжийн ажилчдын хөдөлмөрийн нөхцлийг тогтоолгож, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны өвөл, зуны хувцас, хамгаалах хэрэгслээр ханган, цалин хөлсийг нэмэгдүүлнэ.</p> <p>5. MNS:6561 стандартын шаардлага хангаагүй хаягдал ус нийлүүлдэг үйлдвэр аж ахуйн нэгжид урьдчилсан цэвэрлэх байгууламж суурилуулах арга хэмжээ авч ажиллах.</p>	<p>Цэвэрлэх байгууламжийн ашиглалт үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй “Онги-ус суваг” ТБОНӨО ХХК, “Хархорин ус суваг” ОНӨААТҮГ-ууд тус тус хариуцан ажиллаж байна. Арвайхээр сумын цэвэрлэх байгууламжийн аэротенкийн агааржуулалтын насосын эвдэрлийг засварлахаар энэ онд аймгийн орон нутгийн төсвийн 45 сая төгрөгөөр агаарын 4 ш насос худалдан авч, суурилуултыг хийгээд байна. Арвайхээр сумын цэвэрлэх байгууламжид урсгал засвар шинэчлэлийн ажил хийгдсэн. Хайрхандулаан сумын цэвэрлэх байгууламж дээр 2 ш дүүжин насос шинэчилсэн. Мөн энэ онд Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд технологич инженер, дарга, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан, ашиглалтын инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан, засварчныг сургалтад хамруулж мэдлэг, мэргэжлийг дээшлүүлсэн. Мөн өөр мэргэжилтэй болон мэргэжилгүй 13 ажилчинг аймгийн политехникийн коллежид сантехникийн болон өргөн мэргэжлээр суралцуулж мэргэжилтэн бэлтгээд байна. Цэвэрлэх байгууламжийн ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны өвөл, зуны хувцсыг 2 жилд 1 удаа олгон хамгаалах хэрэгслээр ханган ажиллаж байна. Хужирт сумын рашаан сувиллын газруудыг урьдчилсан цэвэрлэх байгууламжтай болгох шаардлагыг тавьж хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Технологич инженерийг Монголын Нийтийн аж ахуйн холбоон дээр 14 хоног, химич лаборантыг 10 хоногийн сургалтад тус тус хамруулсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт-100.0 хувь</p>
----	--	--	-------------------------------------	---	--

68	Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөл /инженерийн шугам сүлжээ/-ийн эд хөрөнгийн бүртгэл, судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэж тогтмол баяжилт хийж байх.		Мэдээллийн санд шинээр болон шинэчлэн бүртгэгдсэн Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөл /инженерийн шугам сүлжээ/-ийн эд хөрөнгийн тоо	Хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажилласан байна.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 16/13 дугаар тогтоолоор 2019 онд ашиглалтад орсон цэвэр, бохир ус, дулааны 1,6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 3089м шугам сүлжээний эзэмшигчийг тогтоон, ашиглалтыг мэргэжлийн байгууллагад хариуцуулсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Инженерийн шугам сүлжээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 18/ 21 дүгээр тогтоолоор цахилгаан, дулаан, цэвэр ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний эзэмшлийн заагийг тогтоож, тухайн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосон. Үүний дагуу Сууц өмчлөгчдийн холбоогоор эд хөрөнгийн бүртгэл, судалгаа хийх ажлыг хамтран зохион байгуулж, өмчлөлд бүртгэгдсэн шугам сүлжээний аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж байна. Хэрэгжилт-90.0 хувь
Дундаж үнэлгээ					89,5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР					
69	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хүрээнд улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжийн ашиглагч байгууллагыг тодорхойлон, өмчлөлд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэн бүртгэх, мэдээ тайланг хагас, бүтэн жилээр ирүүлэх.		Холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулсан байх	Хөрөнгө өмчлөлд бүртгэгдэж, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.	Энэ онд хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийг бүрэн ашиглалтад орж улсын комисс хүлээн авсаны дараагаар өмчлөлд бүртгэх, шилжүүлэх ажил хийгдэнэ. Хэрэгжилт-90.0 хувь
70	Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, байгууламжийн төсөвт өртгөөс Барилгын тухай хуульд заасны дагуу норм, нормативын санд холбогдох шимтгэлийг		Холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулсан байх.	Орон нутагт баригдаж буй барилга, байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэлийг бүрэн төвлөрүүлсэн байна.	Улс, орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгөөр гүйцэтгэх барилга угсралтын ажлын гэрээнд норм, нормативын сангийн мөнгийг тусган 2024 оны байдлаар 28 барилга угсралтаас 32,98 сая, 9 засвар угсралтын ажлаас 1,6 сая төгрөг төвлөрүүлэн ажлаад байна.

	төвлөрүүлэх, мэдээ тайланг улирал бүр ирүүлэх.				Хэрэгжилт-90.0 хувь
71	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт болон явцын гүйцэтгэлийн мэдээ тайланг сар бүр ирүүлэх.		Холбогдох журамд заасан мэдээллүүдийг бүрэн агуулсан байна.	Мэдээ тайланг хугацаанд нь ирүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин ирсэн барилга угсралтын ажлын 32, инженерийн шугам сүлжээний-5, гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга угсралтын-1, инженерийн шугам сүлжээний-1, их засварын-1, эрх шилжин ирээгүй инженерийн шугам сүлжээний-3 төсөл арга хэмжээний явцад захиалагчийн хяналт хийж ажилласнаас нийт 8 төсөл арга хэмжээг байнгын ашиглалтад оруулж ажилласан Тайланг салбар бүрээр бэлтгэж “Барилгын хөгжлийн төвд” хагас, бүтэн жилээр гарган хүргүүлсэн. Хэрэгжилт-100.0 хувь
72	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр шилжин хэрэгжиж буй болон шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан барилга байгууламжийн гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс талуудын харилцан уялдааг хангаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах.		Хамтын ажиллагааны хүрээнд үр дүн гарсан байна.	Хөрөнгө оруулалтын ажлууд төлөвлөсөн хугацаанд чанартай, үр дүнтэй хэрэгжиж, төсвийн хөрөнгийн үр өгөөж сайжрах нөхцөл бүрдэнэ.	Сургууль, цэцэрлэг дотуур байрны нүхэн жорлонг бага оврын ариун цэврийн байгууламжаар солих ажил 13 суманд хэрэгжиж байгаа ба ажил гүйцэтгэх явцад зураг төсөвт тусгагдаагүй, зайлшгүй өөрчлөх шаардлагатай ажлууд гарч байна. Тухайлбал Гучин-Ус, Төгрөг, Зүүнбаян-Улаан, Уянга, Баруунбаян-Улаан сумдад гарч буй ариун цэврийн байгууламжийн байршил, шугамын өөрчлөлт зэрэг асуудлуудыг төслийн нэгж, Барилгын хөгжлийн төв, зохиогч гүйцэтгэгч ашиглагч талуудтай хамтран тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Мөн Уянга сумын ерөнхий боловсролын сургуулийн урлаг заал, номын сангийн барилга, сумын хөгжил хөтөлбөрөөр хийгдэж буй цэвэрлэх байгууламжийн байршлыг өөрчлөх, Хужирт сумын цэвэр усны шугамын ажилд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад хүсэлтийг хүргүүлэн шийдвэрлүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт-100.0 хувь
Дундаж үнэлгээ					95

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР					
73	“Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 2023/02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах;		Албан даалгаврын хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээнд албан даалгаврын хэрэгжилт хангагдсан байна.	Өвөрхангай аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/486 дугаар захирамжаар үер, усны эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг байгуулан аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Арвайхээр хотын захиргаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Өвөрхангай АЗЗА” ТӨХК, Эрүүл мэндийн газруудтай хамтран үерээс хамгаалах хамгаалалтын далан, зам, гүүрний ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулж, далан, суваг шуудуу цэвэрлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах талаар холбогдох байгууллагуудад албан мэдэгдэл өгч ажиллаж байна. Хэрэгжилт-90.0 хувь
74	“Барилгын ажлын аюулгүй байдлыг хангуулах зарим арга хэмжээний тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 2023/03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах;		Албан даалгаврын хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээнд албан даалгаврын хэрэгжилт хангагдсан байна.	Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн нийт 25 барилга, байгууламжийн захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч нарт албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллах талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгөн ажиллаж байна. Хэрэгжилт-100.0хувь
75	Нутаг дэвсгэртээ барилга, хот байгуулалтын салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангуулж, хуулийн дагуу арга хэмжээг авч ажиллах;		Барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангасан барилга байгууламжийн тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга байгууламжийн чанар, аюулгүй байдал хангагдсан байна.	Төлөвлөгөөт шалгалт-4 төлөвлөгөөт бус шалгалт-9 урьдчилан сэргийлэх шалгалт-6 нийт 19 шалгалт хийж албан шаардлага-5, дүгнэлт-9, Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа-3 ийг явуулж, нэг ААНэгж, хоёр иргэнд нийт 9.8 сая төгрөгийн торгууль ногдуулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2024 онд 11 барилгын угсралтын чанар аюулгүй байдлыг хангуулж байнгын ашиглалтад оруулах Улсын комиссын бүрэлдэхүүнд барилгын техникийн хяналтын улсын байцаагчийг оролцуулж салбарын хууль тогтоомж,

					техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангуулан ажилласан. Хэрэгжилт-100 хувь
76	Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах.		Шинээр олгосон барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгосон байна.	Яамны нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ ирээгүй байна. Хэрэгжилт-30.0 хувь
77	Улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах;		Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажиллах орчин нөхцөл дээшилсэн байна.	Салбарын хяналтын газраас зохион байгуулсан Улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтад Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийг хамруулсан. Хэрэгжилт-100.0 хувь
Дундаж үнэлгээ					84
СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ, ХБИ-ИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР					
78	Барилгын салбарын ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн цахим судалгааг явуулж, мэдээллийн сан бүрдүүлж, нэгдсэн системтэй холбох, ирээдүйд шаардлагатай ажлын байр, мэргэжлийг тодорхойлон БХБЯ-нд ирүүлэх		Ирээдүйд шаардлагатай ажлын байр, мэргэжилтний тоо	Ирээдүйд шаардлагатай ажлын байр, мэргэжлийг тодорхойлдог болох	Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 68 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Ус хангамж, ариутгах татуургын инженер, сантехникийн инженер, дулааны инженер, барилгын материалын үйлдвэрийн технологийн инженер, мэргэжилтэн, ажилчид аймгийн хэмжээнд дутмаг байна. Хэрэгжилт-70.0 хувь
79	Барилга хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах		Тайлан тоо	Сургалт, сургалтад хамрагдсан ажилтнууд, үнэлгээ, хүйсээр ангилсан болон бусад судалгаа, тайлангийн тоо-2	Өвөрхангай аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдийг хамруулан “Барилга. нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2024” зохион байгуулсан бөгөөд салбарын хүний эрх, жендерийн тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах хөтөлбөртэй холбоотойгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын

					Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Хоролсүрэнгээр “Жендерийн эрх тэгш байдлыг хангах сэдэв”-ийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Хэрэгжилт-100.0 хувь
Дундаж үнэлгээ					85
СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР					
80	Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 2024 оны хагас, бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-1) болон Ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 20... хагас, бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-2)-г заасан хугацаанд холбогдох газарт тайлагнах;		Тухайн жилд ашиглалтад орсон (нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшин) барилгуудын тоо	Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссын дүгнэлт баталгаажсан (нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшин) барилгуудын мэдээлэл бүрдсэн байна.	Үндэсний статистикийн хорооны дэд даргын 2021 оны А/01 дугаар тушаалаар баталсан Ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны мэдээг (маягт А-ОС1) маягтын дагуу улирал тутам гаргаж d.undram@barilga.gov.mn хаягаар 2024 оны 5 дугаар сарын 10 болон 12 дугаар сарын 01-нд тус тус хүргүүлсэн. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай барилга 2024 оны жилийн эцсийн байдлаар 8 байна. Хэрэгжилт-100.0 хувь
81	Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар “Аргачлал батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан “Барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулах ажлын хүрээнд барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулах мэдээлэл” маягт, “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл” маягт, “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл” маягтын дагуу холбогдох мэдээг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд ирүүлэх ажлыг зохион байгуулах;		Ирүүлсэн тайлан, мэдээний тоо	Мэдээлэл, бүртгэлийн маягтын дагуу тайлан, мэдээг тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.	Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар “Аргачлал батлах тухай” тушаалаар батлагдсан Барилга, байгууламж, гадна инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулах ажлын хүрээнд “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл 32 олгосон барилга байгууламжийн мэдээлэл бүртгэлийн маягт, “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан 13 барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл” маягтын дагуу гаргаж 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр anonum_ou@yahoo.com хаягаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Хэрэгжилт-100.0 хувь
82	Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаар хамтарсан		Хамрагдсан тусгай зөвшөөрөлтэй	Бүртгэл, мэдээллийн маягт, зааврын дагуу тусгай зөвшөөрөлтэй аж	Эхний хагас жилийн байдлаар Өвөрхангай аймагт бүртгэлтэй 68 аж ахуйн нэгж байгууллага байна. Барилгын үйл

“Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан маягт, зааврын дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;		аж ахуйн нэгж, байгууллагын тоо	аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.	ажиллагааны тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй 57 аж ахуйн нэгж, хүчинтэй хугацаа дууссан 11 аж ахуйн нэгж байгууллагууд байна. Батлагдсан маягтын дагуу үйл ажиллагааны тайлан мэдээг ирүүлсэн 18 аж ахуйн нэгж байна. Хэрэгжилт-50.0 хувь
Дундаж үнэлгээ				83,3
Ерөнхий үнэлгээ				86,4

ТАЙЛАГНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.МӨНХБАТ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Т.ҮРЖИНПҮРЭВ

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ